

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

/2022 оны жилийн эцсийн байдлаар /

2023.01.23

Дархан-Уул

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу new.unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 41 шийдвэрийн 124 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланг уншин гүйцэтгэв.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын 2023.01.23-ны өдрийн хурлын гишүүдээс өгсөн санал, бодлогын хэлтсүүдээс ирүүлсэн нэмэлт мэдээлэл, статистик тоо баримтад үндэслэн сайжруулалтыг гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүн

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 8 хуулийн 68 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 3 тогтоолын 4 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 14 заалт,
- ✓ ҮАБЗ-ийн 4 зөвлөмжийн 8 заалт,
- ✓ Засгийн газрын 6 тогтоолын 13 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 15 тэмдэглэлийн 17 заалт,

нийт 41 шийдвэрийн 124 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2022 онд цахим санд байршсан шийдвэрийн болон заалтын тоо, үнэлгээг харуулбал:

Хугацаа	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ
2022 оны 5 сар	22	35	69.14%
2022 оны 6 сар	82	194	64.48%
2022 оны 8 сар	59	86	69.29%
2022 оны 9 сар	26	40	68.00%
2022 оны 10 сар	26	40	72.00%
2022 оны 11 сар	30	39	84.84%
2022 оны 12 сар	41	124	87.66%
Нийт /давхардсан тоогоор/	123	558	-

Тайлант хугацаанд цахим санд 7 удаа байршсан (давхардсан тоогоор) 558 заалтын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2022 оны жилийн эцсийн байдлаар **89.60** хувийн хэрэгжилттэй **4.48** онооны үнэлгээтэй байна.

Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Үнэлгээ	Нийт	Шийдвэр, төрөл					
			Монгол Улсын хууль	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБ-ын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	41	8	3	5	4	6	15
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	124	68	4	14	8	13	17
3.	Үүнээс Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	93	61	4	11	4	7	6
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	22	5	-	3	4	2	8
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	9	2	-	-	-	4	3
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь	89.60% буюу 4.48 оноо	95.74% буюу 4.78 оноо	100% буюу 5.0 оноо	93.57% буюу 4.67 оноо	85.0% буюу 4.25 оноо	73.85% буюу 3.69 оноо	73.53% буюу 3.67 оноо

2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан Монгол Улсын 8 хуулийг нэршил, заалтын тоогоор нь танилцуулбал:

1. Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 хуулийн 1 заалт,
2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль / 2021-12-17 / -ийн 46 заалт,
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 хуулийн 12 заалт,
4. Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07. Дугаар 2019-01-01 хуулийн 1 заалт,

5. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай (2020-04-29) хуулийн 1 заалт,
6. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ (2020-05-07) хуулийн 4 заалт,
7. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24 –ийн 1 заалт,
8. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01-ийн 2 заалт,

нийт 68 заалт-ыг хяналтад авч хэрэгжилтийг 95.74% -иар ханган ажилласан байна.

УИХ-ын байнгын хорооны тогтоол 100% хэрэгжилттэй байгаа бол Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт 93.57%, ҮАБ-ын зөвлөлийн зөвлөмж 85.0% хэрэгжилттэй байна. Харин Засгийн газрын тогтоолын хэрэгжилт 73.85% , Засгийн газрын хуралдааны тэмдэглэл нь 73.53%-ийн хэрэгжилттэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

30%-иар үнэлэгдсэн 9 (Хуулийн 2, Засгийн газрын тогтоолын 4, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 3 заалт) заалтын хувьд 2022 онд батлагдсан байх бөгөөд цаашид хэрэгжих боломжтой заалт байна.

2017-2022 онуудад хяналтад авсан шийдвэрийн төрлийг харьцуулж харуулбал:

(тухайн жилийн эцсийн байдлаар)

Он	Заалт, тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
2019	99	1	1	3	2	0	60	4	16	8	4
2020	182	23	1	4	4	8	95	1	23	24	0
2021	152	27	2	4	10	15	67	1	26	0	0
2022	124	68	-	4	14	8	13	-	17	-	-

Дээрх хүснэгтээс харахад тухайн жилд хяналтад авсан нийт заалтын:

2017 онд 58 буюу 54.20%

2018 онд 74 буюу 49.66%

2019 онд 60 буюу 60.60%

2020 онд 95 буюу 52.19%

2021 онд 67 буюу 44.07%

2022 онд 17 буюу 13.70%-ийг Засгийн газрын тогтоол буюу асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх үндсэн дээр баталсан баримт бичгийн заалтууд эзэлж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор уг хуулийн 46 заалыг хяналтад авахаар үүрэг болгосноор хуулийн заалтын тоо мөн тоогоор нэмэгдсэн байна.

Хяналтад авсан заалтын тоог салбараар нь харьцуулсныг харуулбал:

№	Үнэлгээ	Нийт	Салбараар								
			Ерөнхий чиг үүрэг	Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай	Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх	Санхүү төсөв, хөрөнгө оруулалт	Хууль, эрх зүйн	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтэц	Боловсрол, соёл, ш/у, спорт	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	Эрүүл мэнд
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	41	11	7	1	1	2	7	6	2	2
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	124	58	14	2	2	5	16	9	2	3
3.	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	93	45	8	1	1	5	12	4	1	2
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	22	9	6	1	1	-	2	3	1	-
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	9	4	-	-	-	-	2	2	-	1
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		89.60% буюу 4.48 оноо	90.51% буюу 4.52 оноо	87.14% буюу 4.35 оноо	85.0% буюу 4.25 оноо	85.0% буюу 4.25 оноо	100% буюу 5.0 оноо	87.50% буюу 4.37 оноо	74.44% буюу 3.72 оноо	85.0% буюу 4.25 оноо	76.66% буюу 3.83 оноо

- ✓ Ерөнхий чиг үүргийн салбарын чиг үүрэгт хамаарах 11 шийдвэрийн 58 заалтын хэрэгжилт 90.51%,
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын чиг үүрэгт хамаарах 7 шийдвэрийн 14 заалтын хэрэгжилт 87.14%,
- ✓ Батлах хамгаалах, гамшгаас урьдчилэн сэргийлэх салбарын чиг үүрэгт хамаарах 1 шийдвэрийн 2 заалтын хэрэгжилт 85.0%,
- ✓ Санхүү төсөв, хөрөнгө оруулалтын салбарын чиг үүрэгт хамаарах 1 шийдвэрийн 2 заалтын хэрэгжилт 85.0%,
- ✓ Хууль, эрх зүйн салбарын чиг үүрэгт хамаарах 2 шийдвэрийн 5 заалтын хэрэгжилт 100%,
- ✓ Нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэгт хамаарах 2 шийдвэрийн 13 заалтын хэрэгжилт 100%,
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтцийн салбарын чиг үүрэгт хамаарах 7 шийдвэрийн 16 заалтын хэрэгжилт 87.50%,
- ✓ Боловсрол, соёл, ш/у, спортын салбарын чиг үүрэгт хамаарах 6 шийдвэрийн 9 заалтын хэрэгжилт 74.44%,
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиг үүрэгт хамаарах 2 шийдвэрийн 2 заалтын хэрэгжилт 85.0%,

- ✓ Эрүүл мэндийн салбарын чиг үүрэгт хамаарах 2 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт 76.66% байна.

2017-2022 онуудад хяналтад авсан шийдвэрийг зохицуулалтын салбараар нь харьцуулж харуулбал: *(тухайн жилийн эцсийн байдлаар)*

Он	Зохицуулалтын салбараар, үүнээс												
	Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьд, сэргийлэх	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бүтэц	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	Уул уурхай	Эрчим хүч
2017 он	25	17	10	6	15	2	7	4	4	5	10	0	1
2018 он	44	18	7	24	18	9	9	5	3	5	6	1	0
2019 он	30	15	2	1	18	6	8	8	4	4	3	0	0
2020 он	28	18	29	7	28	17	0	12	1	20	6	1	2
2021 он	17	17	26	4	12	15	18	20	-	20	3	-	-
2022 он	58	14	2	5	2	2	16	9	-	13	3	-	-

2017-2022 онуудад:

1. Байгаль орчин, аялал жуулчлал,
2. Зам тээвэр хөгжил,
3. Уул уурхай,
4. Эрүүл мэнд,
5. Эрчим хүчний салбаруудын чиг үүрэгт хамаарах хяналтад авахыг үүрэг болгосон заалтын тоо харьцангуй тогтвортой байна.

Харин дараах салбаруудын хувьд хяналтад авахыг үүрэг болгосон заалтын тооны зөрүү ихтэй байгаа нь харагдаж байна. Үүнд тухайлбал:

1. Ерөнхий чиг үүрэг,
2. Төлөвлөлт санхүү, хөрөнгө оруулалт,
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, дэд бүтэц,
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт,
5. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэгт хамаарах заалтын тоо хамгийн багадаа 5, хамгийн ихдээ 41-ээр зөрүүтэй байна.

Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

1. Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-иар үнэлэгдсэн 9 заалтын хэрэгжилтийг хангуулахад ХЭЗХ, ХБТХОХэлтэс болон НБХэлтэс нь хэрэгжүүлэгч агентлагууд болох УБХэлтэс, ГХБХБГазар, ЭМГазар, МТА, БШУГазруудтай хамтран ажиллах, удаашралтай, гүйцэтгэл

хангалтгүй байгаа шалтгааныг тогтоон, хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодит үр дүнг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад анхаарах,

2. Аймгийн ЗДТГ-ын даргын 2022.01.10-ны өдөр баталсан “Дээд шатны байгууллагад хүргүүлэх хугацаатай мэдээ, тайлангийн хуваарь”-ийн дагуу нэгтгэл тайланг хугацаанд нь ирүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Дөрөв. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:

ЗГХЭГ-ын дэд даргын 2022 оны Дугаар ХЭГ/1645 тоот “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, хүчингүй болсон, тогтмолжсон дараах 6 шийдвэрийн 6 заалтыг цахим сангийн хяналтаас хасуулж, дотоодын хяналтандаа авах тухай саналыг тайлбарын хамт тэмдэглэж, цахим санд баталгаажууллаа.

Хяналтнаас хасах саналтай заалтын тоог 2017-2022 онуудын мөн үетэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2017 он	12	15
2018 он	25	34
2019 он	18	21
2020 он	25	26
2021 он	5	6
2022 он	6	6

Диаграммаар харуулбал:



Хасах саналтай заалтуудыг тайлбарын хамт дэлгэрэнгүйгээр харуулбал:

Шийдвэрийн ийн лэс дугаар	Заалтын лэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжүүлэх заалт	Хариу цах нэгж	Хэрэгжилтийн явц	Тайлбар

2	36	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	МТА	Оюуны өмчийн эрх байхгүй байна.	Дээд шатны байгууллагатаг хамаарах
3	48	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24	11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.)		Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 2-10/1098 тоот албан бичгийг аймгийн БШУГ, ХХҮГ, ОНӨГ, УБХ, Сумдын ЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ, ХХААГ зэрэг 11 байгууллагад үйл ажиллагааг сайжруулан ажиллах талаар чиглэл хүргүүлэн, удирдлага зохион байгуулалт болон мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч хамтран ажилласаны үр дүнд 2022 оны эхний 9 сарын байдлаар 68.0% үнэлгээтэй байсан бол жилийн эцсийн байдлаар 87.66% болж, өссөн дүнтэй байна. № Хугацаа Үнэлгээ 6 сарын байдлаар 64.48% 9 сарын байдлаар 68.0% 10 сарын байдлаар 72.0% 11 сарын байдлаар 84.87% жилийн эцсийн байдлаар 87.66% Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үнэлгээг ЗГ-ын ХШҮ-ний мэдээллийн цахим санд 7 удаа (2022.03.30, 2022.08.28, 2022.10.05, 2022.10.20, 2022.11.05, 2022.11.09, 2022.12.02-ны өдөр) хугацаанд нь байршуулан тайлагнаж ажиллалаа.	Дээд шатны байгууллагатаг хамаарах
10	57	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.12.2. "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	ОНӨГ	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгө, үнэлгээ хийгдээгүй газар эзэмших, ашиглах эрхийг нөхөн үнэлэх ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж, даргын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/14 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж, аймгийн орон нутгийн өмчит 13 хуулийн этгээд хамрагдаж 3 хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн дүн 125.7 сая төгрөг, 12 хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламжийн дүн 7.9 тэрбум төгрөг, нийтийн эзэмшлийн байгууламжийн үнэлгээний дүн 505.9 сая төгрөгөөр хөрөнгийн дахин үнэлгээг шинэчлэн баталгаажуулж 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжүүл, тооцуулсан.

22	81	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах	ХЭЗХ, ИТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр тусгай арга хэмжээ 7, уулзалт хэлэлцүүлэг 9, сургалт сурталчилгаа 38, өдөрлөг зөвлөгөөн 3, нийт 57 удаагийн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Байгууллага, иргэдэд гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх эрх, үүргийг сурталчлах чиглэлээр 38 удаагийн сургалт зохион байгуулж, 4800 гаруй хүн хамрагдаж, 7 төрлийн зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг 2700 ширхэгийг сургалтад ашиглан иргэд, байгууллагад түгээсэн. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл, урлагийн газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргаж баривчлагдсан 57 хүнд хувийн хэрэг нээж, 610 цагийн албадан сургалтыг зохион байгууллаа. Дэлхийн зөн төрийн бус байгууллагатай хамтран 2 удаагийн сургалтаар 26 хамтарсан багийн 150 гишүүдийг чадавхжуулж, 7.1 сая төгрөгийг зарцууллаа. Үр дүн: Нийт 322 кейс бүртгэснээс 310 кейс шийдвэрлэж, 12 кейс шийдвэрлэх шатанд буюу шийдвэрлэлт 96,3%-тай байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд нийт 1954 хүүхэд буюу нийт хүүхдийн 5,2%-ийг хамруулсан.	Үйл ажиллагаа тогтмолжсон
23	84	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	ХЭЗХ НБХ ИТХ	Түр хамгаалах байр нь 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа одоо үндсэн 11, гэрээт хамгаалагч 3, нийт 14 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна. Түр хамгаалах байраар 86 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс насанд хүрэгч 19, хүүхэд 67 байна. Хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл бэлгийн хүчирхийлэл 5, бие махбодын хүчирхийлэл 19, сэтгэл санааны хүчирхийлэл 25, үл хайхрах хүчирхийлэл 37 байна. Түр хамгаалах байр нийт 10 төрлийн үйлчилгээг тогтмол үзүүлж байна.	Үйл ажиллагаа тогтмолжсон
26	99	Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020.04.29	16.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	ОБГ	2022 оны 03 дугаар сарын 01-ны өдөр Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын холбогдох албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр томилогдсон ажлын хэсэг дайчилгаагаар ашиглаж болох 13 эмнэлэгийн барилга байгууламжийн судалгааг гаргаж Улсын Онцгой комисст хүргүүлсэн.	1 удаагийн шинжтэй

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.МӨНХСҮРЭН

